МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЕР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОВХИМОЛ

1-Р САР

2023 ОН


JIGUUR GRAND
GROUP Est. 1989
МАКС ӨРГӨӨ
TSAST
CONSTRUCTION
ЗАГ
ГРУПП
ERELT IMPEX
BASALTWOOL
МОНГОЛБАЗАЛЬТ ХК
Royal New Castle
RNC
ultrasonic
GERMAN QUALITY
NCD GROUP
НОГООН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭНЭ
NBK
UGUUJ KHISHIG CO.,LTD
БУТИ
ERCHIM ENGINEERING LLC
barilga.mn
БАТС-ӨРГӨӨ ХХК
T&G
MCS
property LLC
MONCON
MONGOLIAN CONSTRUCTION GROUP
ERIN
INTERNATIONAL
TESO
properties
DYNAMIC TOWER
SKETCH LLC
БАРМОН
АЛТАН ЖОЛОО
КОНСТРАКШН
VIP RESIDENCE
Valuable Innovative Peaceful
SD
ENGINEERING &
CONSTRUCTION
G.R.C
DOBU
BRIDGE
CONSTRUCTION
ISO 9001
ТУМ АРВИЖИХ
ЗАЙ ГҮЙГ БАРИЛГА ҮЙЛДВЭРЛЭЛ ХХК
УНИВЕРСУМ
ГРУПП
БОДЬ ИНТЕРНЭШНЛ
RENDERBAU
SERUUN
SINCE 1991
HIMON
CONSTRUCTION
InvesCore
СҮНДЭР ОРГОО ТРЕЙД ХХК
ОФФИС ПАРТНЕР
ChMM
construction
GANDIRS
DDMT
"ДИ ДИ ЭМ ТИ" ХХК
БУЯНПЭЛ ХХК
GREEN
RESOURCE
EFES GROUP
RELIABLE PARTNER...
ТАВАН БОГД ПРОПЕРТИ ХХК
Хөөтөн хуч - Амжилтын түлхүүр
NEW TELECOM
Pro Heat
Heating & Construction
ДАБЛЬ ПИРАМИД
КОНСТРАКШН
Ecological
Civil
Construction
АРГАЛАНТ АРВИС ГРУПП
RENDER
ЦАГААН ХУАРАН
КОНСАЛТИНГ
MINES UP
HOME
MORTGAGE
CORPORATION
ТЭНХЛЭГ ЗУУЧ
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
NATIONAL
N.A.P GROUP
BAGANAT URGUU
COMPANY
ULAANBAATAR
PROPERTIES
ТОПОЛОГИ ХХК
ЭРЧИМ ХҮЧ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ДЭД БҮТЭЦ
ХАЙРХАН ГРУПП
oly.mn
Mongolia's home of real estate
EUROIGI
ENGINEERING Co.,Ltd
НОМИН
МИШЭЭЛ
БЕТОН АРМАТУР ХХК
COMFORT IMPEX
ХУРД ГРУПП
ego
ENGINEERING & CONSTRUCTION
МОНГОЛ
АЛТАЙН ЦАГ
INTERNATIONAL
HYUNDAI
ELEVATOR MONGOLIA CO.,LTD
GOLDEN LIGHT
GROUP
МИШЭЭЛ
ГРУПП
MCS
estates
SOYOLC
ENGINEERIN
BUTANGUUD
CONSTRUCTION LLC
БАЯНСҮНДЭРЭЛ
ЦАГААН
ХӨШӨӨ
ТРЕЙД
BULDOORS MON
PERFECT DOOR SOLUTIONS
BOLD
"АТИМОС ТРЕЙД" ХХК
ЭВЭР ТУУРАЙ
PD
Solutions LLC
GLOBAL
ELECTRONICS
a GLOBAL NEGOEL Company
ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН ХХК
РАДИУС ХХК
БАРИЛГА, САНТЕХНИК, ҮЙЛЧИЛГЭЭ
"AGGS" LLC
БОДЬЦОГТ ГРУПП
ЦАГААН УРАН ХИЙЦ
IG CON
ENGINEERING CONSULTANTS
BT Solution
MONGOL 333
CORPORATION
ZINDAA
CONSTRUCTION
Oortsog-Uul
Смарт Грийн
Девелопмент
VISION DEVELOPMENT LLC
A1
ARCHITECTS
ГУРВАН БУХАТ
ГРУПП
GLOBAL
TELECOM
БАЗУРА
ДИЗАЙН
АЛХ ХАДААС ХХК
BDMT
BUSINESS DEVELOPMENT & MANAGEMENT TEAM
HAPPY BUILDING LLC
ИХ МОДУН ХХК
UB GROUP
O&OCH LLC

ОРШИЛ

Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2023 оны 01 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг байгууллагын “Стратеги төлөвлөгөө 2020-2024”-ийн зорилтын дагуу товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.1: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖИЛ

БАРИЛГЫН САЛБАРЫН ТББ-ЫН УДИРДЛАГУУД САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ БОЛОН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖТОЙ АСУУДЛУУДАА МОНГОЛ УЛСЫН УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БХБ-ЫН САЙД Ц.ДАВААСҮРЭНД УЛАМЖИЛЛАА



Монгол Улсын барилгын салбарын хувьд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд салбарын барилгын тусгай зөвшөөрлийн олголт, мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг төрийн бус байгууллагууд нь гэрээний үндсэн дээр хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд Монгол Улсын УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, БХБ-ын Сайдаар томилогдсон Ц.Даваасүрэнтэй 2023.01.17-ны өдөр салбарын 30 гаруй байгууллагын төлөөллүүдийг хүлээн авч уулзлаа.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: БАРИЛГЫН САЛБАРТ ТУЛГАРААД БАЙГАА 250 ГАРУЙ АСУУДЛААС 25-ЫГ ЭРЭМБЭЛЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧМААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Салбарын ТББ-ын төлөөллүүдийг цаг гарган санал бодлыг нь сонсъё гэж урьсан Монгол Улсын УИХ-ын гишүүн, БХБ-ын сайд Ц.Даваасүрэн болон яамны удирдах албан тушаалтнуудад талархал илэрхийлье. Миний бие нь МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчөөр өнгөрсөн оны 5-р сараас эхлэн ажиллаж байна. МБҮА ТББ нь 2009 онд анх үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, өдгөө бид эгнээндээ барилгын салбарын тэргүүлэгч хөрөнгө оруулагч, үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгч, реалтор, барилга угсралт, архитектур, зураг төсөл, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч чиглэлийн 144 гаруй идэвхтэй үндэсний бүтээн байгуулагч гишүүн компаниудыг сайн дурын үндсэн дээр эгнээндээ нэгтгэсэн, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна, төрийн зарим чиг үүргийг бусад түншлэгчтэйгээ хамтран хэрэгжүүлж байна. Манай гишүүн компаниудын 70 орчим хувь нь төсөл хэрэгжүүлэгчид, үлдсэн нь зураг төсөл, архитектурын компаниуд байдаг. МБҮА ТББ нь байгуулагдсан цагаасаа эхлэн салбарынхаа хөгжлийг түргэсгэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр ажиллахаас гадна яамтайгаа ил тод, нээлттэйгээр ажиллаж ирсэн. Өнгөрсөн хугацаанд ямар нэгэн шүүмжлэл гомдол тавихаасаа илүүтэй аливаа асуудлын гарц шийдлийг хайж ажиллая гэсэн зарчимтайгаар ажиллаж байгаа. Ийм учраас бид өнгөрсөн хугацаанд 3 удаагийн Стратеги төлөвлөгөөгөө хийж, байнга шинэчлэн сайжруулж мэргэжлийн консалтинг байгууллагуудтай, экспертүүдтэй тогтмол нягт хамтран ажиллаж байна. Сүүлийн 3 жилд манай салбарынханд хил гааль, “Тэг ковид”-ын бодлогын улмаас багагүй хүндрэл тулгарч байгаа учир бид илүү эвлэлдэн нэгдэх байдлаар ажиллах хэрэгтэй болсныг харуулж байна. Үүнээс гадна, бид асуудлуудаа нэлээн гарц шийдэл хайж ажиллах хэрэгтэй гэсэн зарчмаар 4-5-хан сарын өмнө Стратеги төлөвлөгөөндөө шинэчлэлийг хийж барилгын салбарт тулгараад байгаа 250 гаруй асуудлуудыг шинжлэн судалж, түүнээсээ 25 асуудлыг эрэмбэлэн төслийн удирдлагын зарчмаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн байдлаар ажиллаж байна. Ингэж ажиллахад гишүүдийн оролцоо их чухал бөгөөд зөвхөн шүүмжлээд суух биш өөрсдөө оролцоод, мэргэжлийн хүмүүсийг оролцуулаад шийдээд явах нь чухал гэдгийг гаргаад явж байна. Шинээр томилогдсон сайддаа ажлын өндөр амжилтыг хүсээд салбартаа

байгаа бүх асуудлуудыг анхаарч, хувийн хэвшил, тэр дундаа идэвхтэй ажиллаж байгаа олон нийтийн байгууллага, мэргэжлийн холбоодтойгоо энэ ажиллаж байгаа хугацаандаа нэлээн гүнзгий, нягт хамтран ажиллах байх гэж найдаж байна.

Монголын Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбооны Тэргүүн М.Түмэнжаргал: ХИМИЙН ҮЙЛДВЭР БАРИХ ХЭРЭГТЭЙ

Холбооны зүгээс 2 саналыг хэлэх гэсэн юм. Холбооны зүгээс барилгын материалын үйлдвэрийн салбар жигд явж байгаа ч 2 асуудал их дутагдалтай байна.

1. Арматур буюу гангын үйлдвэрийн асуудал жилээс жилд яригдаж байгаа ч урагшаа явж өгөхгүй байгааг анхааралдаа авна уу.
2. Энэ салбарт химийн бүтээгдэхүүн маш их хэрэглэгддэг. Гол түүхий эд нь нефть байдаг. Дорноговь аймагт нефтийн үйлдвэрийг барьж байгаатай холбогдуулан химийн үйлдвэрийг барьж эхлэхэд анхаарал тавиарай.

Монголын Зураг төсөл зохиогчдын холбооны Ерөнхийлөгч Н.Дорж: ЗУРАГ ТӨСЛИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛЪЯ ГЭВЭЛ МАГАДЛАЛЫН ЭРХИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТТАЙГААР ӨГӨХ ХЭРЭГТЭЙ

Манай холбоо нь 2007 онд байгуулагдсан, 140 гаруй гишүүдтэй байгууллага. Энэ уулзалтад гурван асуудал хөндье.

1. Зураг төслийн чанар муу байна гэдэг дээр олон жил ярьж байгаа ч өөрчлөлт гарахгүй байна. “Барилгын тухай” хуульд зураг төслийн магадлалд иргэн ба хуулийн этгээдийг сонгоно шалгаруулна гээд заасан байгаа. Тиймд үүнийг ажил хэрэг болгох хэрэгтэй.
2. Түншлэлийн хүрээнд барилгын яамтай хамтран зураг төслийн компаниудыг чадавхжуулах хүрээнд сургалт зохион байгуулдаг. Энэ нь хоёр газар явдаг. Архитектурын холбоо дээр бас явагддаг, үүнийг бас түншлэлийн гэрээтэй болгоод, сургалтын нэгдсэн хөтөлбөртэй болгоод нэгтгээд явах нь илүү тохиромжтой болов уу.
3. Хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлж байгаа байдал нь маш хариуцлагагүй байна. Энэ салбарт би 35 жил ажиллаж байгаа хүн. Тиймээс бодлоготой болгож, орон тооны бүтэцтэй болгож тусгаж өгөөч ээ. Хот байгуулалт гэдэг чинь маш өргөн цогц асуудал. Өнөөдөр бидний хувьд хот байгуулалт, суурин иргэншлийн асуудал үнэхээр асуудал болж байгаа. Тиймээс энэ тал дээр анхаарал хандуулж алхам хийх хэрэгтэй байна. Боломж байгаа гэж харж байгаа.

Монголын Барилгын инженерүүдийн холбооны Тэргүүн дэд ерөнхийлөгч Х.Мурат: ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИЖ АЖИЛЛААРАЙ

Энэ өдрийн мэндийг хүргэе. МБИХ нь 1996 онд үүсгэн байгуулагдсан, зураг төсөл, угсралт, материалын үйлдвэрлэл зэргээр ажилладаг 240 гаруй гишүүдтэй, орон нутагт салбартай, гаднын 17 байгууллагатай холбоотой ажилладаг байгууллага билээ. Өнөөдөр шүүмжлэл гэхээсээ илүүтэйгээр төр, хувийн хэвшлийн хэвшиж эхэлсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллаарай гэсэн саналыг хэлье.

Барилгын төсөвчдийн холбооны Тэргүүн Ү.Банди: БАРИЛГЫН АЖИЛЧДЫН ТАРИФТ ЦАЛИНГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

Энэ оноос эхлэн цалингийн доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан барилгын ажилчдын тарифт цалинг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ гарч ирж байна.

1. Төсвийн нормыг боловсруулж дуусгах хэрэгтэй байна.
2. Төсөв задгайгаар явж байгаа, жишиг байдлаар ч явж байгаа. Хөдөлмөрийн зарцуулалт, төлөвлөлт, судалгаа г.м. хийгээд явж байгаа. 3. Сургалтын хувьд Барилгын нэгдсэн холбоотой, барилгын тусгай зөвшөөрлийн хувьд МБҮА ТББ-тай түншлээд ажиллаж байгаа. Тиймээс барилгын ТББ-ууд болон төр нь нэгдсэн бодлоготойгоор хамтран ажиллах цаашдын алхамд нь анхааараарай гэдгийг хэлэх байна.

Монголын Барилгын үйлдвэрчний эвлэлийн хорооны Дарга Б.Батцогт: БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙГ АНХААРАХ ХЭРЭГТЭЙ

Бид яамтай хэлэлцээрийн хүрээнд ажилладаг. Хэлэлцээрийн хүрээнд нэлээн их ажлыг хийсэн. Тэр дундаа нэг ажлыг 6 жил хөөцөлдөж байж сая 2022.12.22-нд батлууллаа. Манай барилгын салбарт 2010 оноос хойш нэг ч хийгдэж байгаагүй, одоо үүнийг дагасан стандартыг гаргах хэрэгтэй байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан барилгын салбарын ажилчдын цалинг нэмэх нөхцөл байдал үүсэхээс гадна цалингийн жишиг тарифыг батлах шаардлага үүсэж байна. Мөн барилгын салбарын ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг анхаарах хэрэгтэй байна.

Зөвлөх мэргэжилтэн, экспертүүдийн шинэчлэл холбооны Ерөнхийлөгч Л.Шагдаррагчаа: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА НЬ ҮНИЙГ ТОГТООХ ЁСГҮЙ

Энэ салбарт тулгамдсан, бэрхшээлтэй, шийдвэрлэгдээгүй олон жил бугшсан бодлогын шинж чанартай хэдэн асуудлуудын талаар ярих нь зүйтэй байх аа. Манай салбар 100 хувь хувьчлагдсан. Тиймээс барилгын салбарын удирдлага, зохицуулалтын асуудлууд, төрийн ерөнхий зохицуулалтаас гадна хүний амьдрах орчны аюулгүй байдалтай холбоотой техникийн зохицуулалт энэ 2-ыг яам удирдлагаараа хангаж явах ёстой. Төрийн бодлого нь хуулиараа дамжиж, техникийн зохицуулалт нь актуудаараа дамжиж амьдралд хэрэгжинэ. Барилгын суурь харилцааг зохицуулах ёстой “Барилгын тухай” хууль нь нэрээсээ авхуулаад л доголдолтой, бүхэл бүтэн бүлгээр нь хуульчлаад заачихсан харилцаа, түүнийг хэрэгжүүлэгч байгууллага нь хууль батлагдсан 2016 оноос хойш өнөөдрийг болтол хэрэгжихгүй байгаа асуудлыг жишээ болгож ярья. “Барилгын тухай” хуулийн 31-р зүйлд 15 чиг үүргийг хэрэгжүүлэгч агентлаг хэрэгжүүлнэ гэж зааж өгсөн байгаа. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэгч агентлагийг байгуулаагүй учраас Барилгын сайдаар томилогдсон үе үеийн хүмүүс нь төрийн өмчит аж ахуйн тооцоот газарт төрийн захиргааны байгууллагын хуулиар тусгайлан заасан чиг үүргийг шилжүүлэн өгч байна. Би БХТ-ийг шүүмжилж байгаа юм биш. Үүнээс болоод 2016 оноос хойш “Барилгын тухай” хууль чинь хэрэгжихгүй байна аа. Тэр дотор заасан 15 чиг үүргийг өнөөдөр энд оролцож байгаа ТББ-уудад нэг нэгээр нь гэрээг нь байгуулаад, эрхийг нь өгөөд хийлгэж байна. Тиймээс тэд салбарыг хөгжүүлэх биш, харин зүгээр л гэрээт ажлыг хийгээд явах сэтгэхүйгээр ажиллаж байх жишээний. Захиргааны ерөнхий хуулийн 8.1-т хуулиар тусгайлан заасан төрийн захиргааны чиг үүргийг шилжүүлэхийг хориглоно гээд заасан байгаа.

1. Сая “Зөвшөөрлийн тухай” хууль батлагдлаа. Энэ хуульд бас тэгээд заасан байгаа. Тухайлбал, ерөнхий барилгын ажилд 3 төрлийн барилгын зөвшөөрлийг өгч байгаа, МБҮА ТББ нь. Түүнийг дотор нь жижиглээд 30-40 төрлийн ажил болгоод тэр болгоноос нь тусгай зөвшөөрлийн шимтгэлийн хувь хэмжээг тогтоогоод дураараа аашилж байна. Энэ завхралыг хуулиар засах ёстой байх.
2. 2019 онд Засгийн газраас шийдвэр гаргаад салбарын төрийн бодлогын баримт бичгийг гаргасан. 6-7 сард холбогдох яам нь төрийн бус байгууллагуудтай хамтраад салбарын бодлогыг гаргаж, тэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сайд баталсан. Дараа нь 8-р сард У.Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа салбар бүрийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт, стратегийн баримт бичгийг боловсруулсан. Тэгээд 2 үе шаттайгаар 2045 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргасан. Барилгын салбарын 2025 он хүртэлх баримт бичгийг баталсан. Яагаад үүнийг яриад байна вэ гэвэл эдгээр батлагдсан баримт бичгээ манай яамныхан, газар, хэлтэс, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагууд нь ерөөсөө ч авч үзэхгүй, шүүгээндээ далд хийчихсэн. Ийм их цаас, цаг зав үйлдвэрлүүлчхээд түүнийгээ хэрэгжүүлэхгүй байгаагаас салбарын хөгжил нь урагшаа явахгүй байна. Энэ салбарт 6 үндсэн шинэчлэлийг хийнэ гээд төрийн бодлогын баримт бичигт нь тусгасан байхад сөхөж харж байгаа хүн байгаа юм уу. Энэ бодлого, шийдвэрүүдээ хэрэгжүүлэхийн оронд өөр яамны чиг үүргийг авч ажил хийсэн дүр үзүүлж байна. Энэ

явдлыг таслан зогсоох ёстой. Гэтэл манай яамны хийх ёстой зам тээврийн бүтээн байгуулалтын суурь бүтцийн, эрчим хүчний барилга байгууламжийн асуудлуудыг, тэрний норм дүрмийг нь барилгын салбар батлах ёстой, салбар дундын зохицуулалтын журам дүрэм байсаар байхад өөр яамны сайд батлаад сууж байх юм. Тэрний тусгай зөвшөөрлийг олгож байна. Энэ салбар дундын ойлгомжгүй асуудлуудыг Сайд та одоо нэг талд нь гаргах хэрэгтэй. Сая “Стандарт, техникийн зохицуулалтын тухай” хууль гарсан. Энэ хуулиар салбарын яамд дэргэдээ Техникийн зохицуулалтын хороотой байх ёстой. Гэтэл энэ хороог одоо хүртэл байгуулаагүй. Тэгээд юм ярихаар төрийн өмчит БХТ рүү чихээд байх юм. БХТ бол аж ахуйн тооцоотой компани. Үнэхээр цааш нь ажиллуулмаар бол, төрийн чиг үүргийг хэрэгжүүлмээр бол хариуцсан шиг хариуцуулмаар байна. Нэг бол хувийн хөгжлийн компаниудтай зэрэгцэж бизнес хийдэг байгууллагыг компани болгох хэрэгтэй.

3. Үнэ бүрдэл: 1976 онд баталсан, ОХУ-ын үнэлгээ. 6-7 төрлийн барилгын ажлыг шинэчилсэн байгаа нь ОХУ. Тэрийг хуулаад, хэн, хаанаас, ямар аргачлалаар тогтоосон нь мэдэгдэхгүй, энд тэндхийн юмаар хөрвүүлээд, нэг нь нөгөөдөө тохирохгүй юмаар барилгачдын цуглуулсан нормчлолын сангийн мөнгийг үрж байгаа. Дэлхийн зах зээлийн нийтлэг жишигтэй бусад улс орон нь энэ асуудлыг шийдсэн байна. Үүнийг одоо байж байгаа төсвийн норм нэгжийг томсгоод, томсгосон үнэлгээ, томсгосон цаг хугацаатай болгоод жишиг болгоод тэрийг нь баталж өгөх ёстой. Тэрнээс өнөөдрийн яамны, БХТ-ийн зохицуулж байгаа шиг үнийг индекслээд, үнэ тогтоодог энэ балай юмаа зогсоох ёстой. Сүүлд нь энэ чинь асуудалд орно шүү. Төрийн захиргааны байгууллага нь үнийг тогтоох ёсгүй. Олон улсад шинжлэх ухаанаар батлагдчихсан, төслийн удирдлагын арга зүйгээр өөрчлөлтийг хийж, үнэ, нормыг тогтоох хэрэгтэй.

Нийслэлийн Ерөнхий архитектор, МАЭ-ийн Ерөнхийлөгч Н.Нацагдорж: ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАГДСАНЫ ДАРАА ДАГУУЛ ХУУЛИУДАА ӨРГӨН БАРИХ ХЭРЭГТЭЙ

“Газрын тухай” багц хууль, удахгүй “Барилгын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт орох гэж байна. Гэтэл энэ хуулиудыг батлуулахаас өмнө “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г бодлогоор хянадаг, жил жилийн бүтээн байгуулалт нь энэ төлөвлөгөөтэй нийцэж байна уу гэдгийг хянаж байж явдаг баймаар байна. Тэгээгүйгээс өнөөгийн Улаанбаатар хотын байгаа байдлыг та бүхэн харж байна. Тиймээс цаашдаа 2040 оны Ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар батлуулсны дараа дагуул хуулиудаа өргөн барьж, хэрэгжүүлэх талаар хэлэлцэх хэрэгтэй байна. Ерөнхий төлөвлөгөөг батлагдсаны дараа олон асуудлууд яригдана. Энэ тал дээр анхаарал хандуулаач.

Монголын Барилгын хөгжлийн үндэсний төвийн Тэргүүн Г.Мягмар: БАРИЛГЫН САЛБАРТ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ НЭН ЧУХАЛ БАЙНА

1. Хот байгуулалтын бодлого байхгүй, бодлогын баримт бичиг ч алга. Ийм баримт бичиг батлагдаагүй нөхцөлд Монгол Улсад хаана хот суурин бий болж, хаана юу барих вэ гэдгийг яриад хэрэггүй. Тиймээс энэ тал дээр анхаараач ээ.
2. Монгол Улсын хэмжээнд техникийн бодлогын нормын асуудал нь нэгдсэн бодлого зохицуулалтай байх ёстой. Тиймээс техникийн норм, шинэчлэлийн асуудал их хоцорч байна. Тиймээс салбарын Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага зайлшгүй хэрэгтэй байна.
3. Барилгын салбарт хэрэгжээгүй, хөгжөөгүй зүйл бол Зөвлөх үйлчилгээ байна. Үүнийг хөгжүүлж чадвал энэ салбарт маш олон асуудал шийдэгдэнэ.
4. Шат дамжлагыг багасгасан, хүнд суртлыг багасгасан, авлигын асуудлыг бүр байхгүй болгомоор байна. Барилгаа ашиглалтад өгсөн хүмүүс нь Комисс гэдэг чинь ямар байдгийг хэлээд өгнө дөө. Энэ тал дээр маш их анхаарал хандуулаарай.

Монголын Барилгачдын нэгдсэн холбооны Ерөнхийлөгч М.Батбаатар: ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД НЬ ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ МАШ САЙН ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА

1. Салбарын 40 гаруй ТББ байна. 5 жилийн өмнөөс төрийн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулж, өнөөдрийн байдлаар нийт 21 барилгын ТББ нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Тиймээс төртэй харьцаж сурч байна, төрийн итгэлийг авч төрийн чиг үүрэг, ажлыг чанартай, хүнд сурталгүйгээр, хүртээмжтэй ажиллахад холбоод нь маш туршлагатай болсон байна. Түншлэлийн хүрээнд манай ихэнх холбоод сургалтын танхимтай, сургалтын боловсон хүчинтэй болсон. Тиймээс энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн босгосон энэ туршлагыг цаашид ашиглаад яваасай.
3. Одоо барилгын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлуудад анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Ийнхүү бүтэн 2 цаг гаруй үргэлжилсэн уулзалтын үеэр салбарын төрийн бус байгууллагын төлөөллүүд нь салбарт тулгамдаж буй олон асуудлуудын талаар санаа бодлоо солилцож, хууль эрх зүйг боловсронгуй болгох, сайжруулах, өөрчилж шинэчлэх асуудлууд байгааг Барилга, хот байгуулалтын Сайддаа уламжилж, шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллахыг хүслээ.

Харин Барилга, хот байгуулалтын Сайд Ц.Даваасүрэн нь цаашид яам, төрийн бус байгууллагын хооронд тогтсон түншлэлийн харилцааг бэхжүүлж ажиллахаас гадна гэрээг сунгахдаа дотоод аудитыг ажиллуулж, хариуцлагатай ажиллах шаардлагыг тавихаа илэрхийллээ. Мөн мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхжуулах хүрээнд мэргэжлийн сургалтын төвүүдтэй түншилж, хамтран ажиллах нь зүйтэй гэсэн бол барилгын тусгай зөвшөөрлийн олголтыг зөвхөн барилга барих хугацаанд нь тухайн барилгад нь олгоод явбал барилгын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн худалддаг байдал арилна гэдгийг онцолж байв.

Мөн хот байгуулалтын гол эрх зүйн баримт бичиг болох “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г батлуулах тал дээр анхаарал хандуулж “Барилгын тухай” хуулиар бүрэн зохицуулагдахгүй байгаа асуудлууд, техникийн норм, нормативын бичгүүд, зургийн чанар тааруу байгаа зэрэг бүхий л асуудлуудыг судалж үзэх тухайгаа илэрхийлсэн юм. Түүнээс гадна, барилгын салбарын эрдэм шинжилгээний байгууллагагүй явах нь энэ салбарт олон асуудлыг дагуулж байгааг анхаарч энэ чиглэлээр судлахаас гадна Төрийн бус байгууллагууд нь Гишүүн байгууллага бүрдээ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр хяналтаа чангатгах, ажилчдадаа амласан цалингаа цаг тухайд нь олгож байхыг хичээнгүйлэн хүсээд энэхүү уулзалт өндөрлөсөн билээ.


БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН Л.ШАГДАРРАГЧААТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, УЗГ, Барилга.мн ХХК-ийн захирал Г.Батсүх нар Барилга корпорацын ТУЗ-ийн дарга, Гавьяат барилгачин Л.Шагдаррагчааг хүлээн авч уулзаж, Барилгын салбарын хуулийн шинэчлэлийг хурдтай өөрчлөгдөн хөгжиж буй салбарын хөгжилттэй нийцүүлэх, төслийн менежментийн үзэл баримтлал, зах зээл, бизнесийг дэмжих, хөгжлийг түргэсгэх бичиг баримт болгон хөгжүүлэх талаар санал бодлоо солилцож, энэхүү ажлыг цаашид хамтран хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцлаа.

Уулзалтын үр дүнд Л.Шагдаррагчаа нь өөрийн боловсруулж буй салбарын хуулийн үзэл баримтлал, системчлэлийн талаар МБҮА ТББ-ын нийт гишүүдэд зориулан илтгэл, хэлэлцүүлгийг хийхээр боллоо.

МБҮА ТББ НЬ ШИНЭ ЛОГО, БРЭНДТЭЙ БОЛЛОО



МБҮА ТББ нь “Стратеги төлөвлөгөө 2020-2024”-н тодотголын хүрээнд Монголын үндэсний бүтээн байгуулагч компаниудын нэгдэл, утга бэлгэдлийг агуулсан, шинэ имиж, шинэ өнгө төрхийг бүрдүүлсэн логог бий болгон танилцуулж байна. Дээрх логоны утга санааг “Бид Монгол агуулга”-ын Дизайнер Э.Бадрах хийж бүтээлээ. Э.Бадрах нь Монголын томоохон компаниуд болон олон нийтийн байгууллагуудын лого дизайныг гаргадгаараа салбартаа нэр хүндтэй дизайнер бөгөөд МБҮА ТББ-ын логоны утга санааг ийнхүү бэлгэдэн бүтээжээ.

Өлзий хээ: Өөд өөдөө дэвшин дээшлэхийн өлзий ерөөлийг бэлгэдэн шингээсэн. Мөн өлзий хээний гэрийн ханын адил тасралтгүй үргэлжлэх зураас нь хэзээд ч төгсгөлгүй сайн сайхны дээдийг ерөөн бэлгэдсэн. Түүнчлэн, Монголчууд эрт дээр үеэсээ эхэлж айл гэрийн үүд хаалгандаа чимэг болгон дээдлэн ирсэн байна.

Монгол гэр: Монгол гэр, гэрийн ханын адил дүрснээ хөврөн гарч буй нь барилгын цэгцтэй бүтэц болон нар зөв эргэлдэж буйг илэрхийлсэн байна.

Барилга, хот байгуулалт: Хотын цэгцтэй, зөв төлөвлөлтийг уг хээний тэгш байгуулалтаар адилтган илэрхийлсэн байна.

“ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ” (REIT-REAL ESTATE INVESTMENT TRUST) ТӨСӨЛД САНАЛ ОРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙГ БАЙГУУЛНА



“Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн тухай” (REIT-Real Estate Investment Trust) хуулийг санаачилж, төслийг нь боловсруулахад хамтран ажиллах талаар МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, "Улаанбаатар ассет менежмент” ХХК-ийн захирал Н.Монсор, “Тэнхлэг зууч” ХХК-ийн захирал Д.Должинсүрэн нартай уг асуудлаар өмнө нь уулзаж байсны дагуу уг хуулийн төслийг ажил хэрэг болгох, эрчимжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийхээр тохиролцлоо. Үүнд:

✅ Хуулийн ач холбогдлыг гишүүдэд танилцуулах
✅ Хамтран хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллах.

“Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн тухай” хууль хэрэгжсэнээр барилга, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбож хөгжүүлэх боломж бүрдэх ба барилга, үл хөдлөх хөрөнгийн бизнест санхүүжилт, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бий болгох, хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах зэрэг олон давуу тал бизнес эрхлэгчдэд бий болох юм. Иймд Олон улсын жишиг, туршлагыг салбартаа нэвтрүүлэх, хууль эрх зүйн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд бизнес эрхлэгчдийн дуу хоолой, оролцоо чухал үүрэгтэй болох юм. Энэхүү хуулийн зохицуулалт болон ирээдүйн зах зээлтэй холбоотой танилцуулгыг “Дээвэр” холбооны зүгээс 2023.02.02-ны өдөр МН Таэурын 7-р давхрын Хурлын танхимд танилцуулав.

МБҮА ТББ-ЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



МБҮА ТББ нь байгууллагынхаа Дүрмийн дагуу жилдээ 2-оос доошгүй удаа байгууллагын санхүү болон үйл ажиллагаанд хяналт-шалгалтыг хийдэг бөгөөд 2022 оны ээлжит 2 дах удаагийн хяналт-шалгалтаа эхлүүлэхээр МБҮА ТББ-ын Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн болох Дарга С.Ганзориг, Гишүүд Ж.Дэлгэрсайхан, Д.Одгэрэл, Х.Бямбасүрэн, Ауюш нар нь 2023.01.27-ны өдөр Ажлын албан дээр хүрэлцэн ирж МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан, Ажлын албаны Үйл ажиллагаа хариуцсан менежер Х.Долзодмаа, Салбарын бодлого хариуцсан зөвлөх Г.Лосол, Нягтлан бодогч О.Мөнхчимэг нартай уулзаж заавар зөвлөгөө, чиглэлээ өглөө. Тус шалгалтын үр дүн, тайлангийн биелэлтийг Хяналтын зөвлөл нь 2023.02.10-ны өдөр зохион байгуулагдах МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн хуралд танилцуулах болно.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.2: ГИШҮҮДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ

БНХАУ-ЫН “Fortune-500” СЭТГҮҮЛИЙН ШИЛДЭГ 500-Д БАГТДАГ “CGGC” ХХК НЬ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАЛАА



МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийн тоог нэмж, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх зорилтын хүрээнд БНХАУ-даа жил бүр болдог “Шилдэг аж ахуйн нэгж” болон бизнес эрхлэгчдийг санхүүгийнх нь орлогоор нь эрэмбэлдэг “Fortune 500” сэтгүүлийн шилдэг 500-д багтдаг “CGGC” компанийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Бэн Жао, Маркетингийн менежер П.Цолмон нарыг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Л.Хулан нар хүлээн авч уулзав. Тус уулзалтын үеэр “CGGC” компанийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Бэн Жао нь МБҮА ТББ-ын Гишүүнээр элсэх, Ассоциацийн гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. “CGGC” компанийн дээрх саналыг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч

Н.Баярсайхан найрсгаар хүлээн авч гишүүнээр элсэхийг дэмжиж, цаашид гишүүн байгууллагууд хоорондын бизнесийн харилцаа холбоог тогтооход туслалцаа үзүүлэхээ мэдэгдлээ.

❖ МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилтын хүрээнд 2023.01-р сард байгууллагынхаа үйл ажиллагааны танилцуулга, гишүүнчлэлийн мэдээ, мэдээллийг барилга угсралтын “China Gezhouba Group Company Ltd” ХХК, “Есөн талт оргил констракшн” ХХК, “Эй ди и пи” ХХК, “Гангар инвест” ХХК, “Мандалт констракшн” ХХК, “Рестар проперти” ХХК, “Нутгийн буян групп” ХХК, “Хар чонот” ХХК, “Өү энд өү си эйч” ХХК болон зураг төслийн “Петронас тауэр” ХХК зэрэг байгууллагуудад хүргэж ажилласны дагуу “Хар чонот” ХХК, “Өү энд өү си эйч” ХХК болон “Петронас тауэр” ХХК зэрэг байгууллагууд нь МБҮА ТББ-д шинээр гишүүнээр элслээ.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.2: БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ


ДУЛААН ШИЙДЭЛ-2” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ

2022 ОНЫ БРИГАДЫН АХЛАГЧДЫН “СЭТГЭЛ ХАНАМЖ”-ИЙН СУДАЛГААГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ



“Дулаан шийдэл-2” төслийн Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчид (Бригад)-ийн сэтгэл ханамжийн судалгаанд 2022 онд идэвхтэй ажилласан нийт 23 (5 эмэгтэй, 18 эрэгтэй) бригадын ахлагчдыг хамруулав. Төслийн багын хийсэн судалгаагаар нийт бригадын ахлагч нарын 45% нь дулаалгын технологийн болон зөвлөхийн чиглэлээр давтан сургах, гүнзгийрүүлэх, дахин суралцах хүсэлтэй байгааг илэрхийлсэн бөгөөд энэхүү судалгааны сургалтын үр дүн нь өмнөх оны судалгааны үр дүнтэй адил гарсан байна. Энэ нь бригадуудад нэмэлт сургалт авахаасаа илүүтэйгээр дадлагажих, сурсан мэдлэг, туршлагаа баталгаажуулах шаардлага өндөр байгааг харуулж байна. Мөн уг судалгаагаар МБҮА ТББ-ын дэргэдэх салбарын гишүүнээр элсэж, цаашид хамтран ажиллах чиглэлээр 45% нь сонирхолтой байна гэсэн бөгөөд салбарын гишүүнээр элсэх гол шалтгааныг дийлэнх нь бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах, ашиг орлогоо нэмэгдүүлэх, тогтмол ажил орж ирэх магадлалтай гэж үзсэн байна. Гишүүнээр элсэх сонирхлоо илэрхийлсэн бригадууд нь гишүүнчлэлийн татварыг 1 жилд 4 хуваах эсвэл 12 сард хуваж төлөх боломжтой гэж хариулжээ.

“ХАН ХӨЛГӨН” ХХК-ТАЙ “АЖЛЫН БАЙРНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ” АЖЛЫН ХҮРЭЭНД УУЛЗАЛТ ХИЙВ



2023.01.09-нд МБҮА ТББ-ын Ажлын албаны “Дулаан шийдэл-2” Төслийн багийн гишүүд нь өөрсдийн боловсруулсан Ажлын байрны цахим системийн хөгжүүлэлтийн Ажлын даалгаврыг дэлгэрэнгүй тайлбарлах үүднээс “Хан хөлгөн” ХХК-ийн менежер Ч.Урандэлгэртэй тус компанийн оффист уулзав. Тус системийн хөгжүүлэлтийн ажил нь 03-р сарын сүүлээр дуусах бөгөөд талууд нь системийн сайжруулалтын ажлын хүрээнд хамтран ажиллах биет болон цахим уулзалтуудыг дахин хийж, гэрээнд заасан хугацаанд Ажлын байрны цахим системийг хүлээн авахаар тохирлоо. Ажлын байрны цахим системийг сайжруулан хөгжүүлэх ажлын явц нь 70 хувьтай байгаа бөгөөд тус системийг ХУР системтэй холбохын тулд Үндэсний дата төв рүү техникийн шаардлагыг илгээгээд байна. Мөн mailgun, qpay зэрэг холболтуудыг хийлгүүлэхээр судалж байна.

“ДУЛААН ШИЙДЭЛ-2” ТӨСЛИЙН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ



“Дулаан шийдэл-2” төслийн 2023 оны хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын хоёр долоо хоног тутмын уулзалт биетээр ЖЭРЭС ОУТТБ-ын оффист болж, МБҮА ТББ-ын Төслийн багын гишүүд оролцож өмнөх хоёр долоо хоногт хийсэн үйл ажиллагаа болон ирэх хоёр долоо хоногт зохион байгуулах үйл ажиллагаагаа тайлагнав. Мөн уг уулзалтаар БЭХХТ-ийн Инженер А.Ганбагана нь загвар сууцын зураг, төслийг танилцуулсан бөгөөд уг танилцуулгын дагуу төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд нь хэлэлцүүлэг хийв.

БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ




“Дулаан шийдэл-2” төслийн шинэ элсэлтийн БЖДБЭ буюу 7-р ээлжийн шинэ бригадуудад зориулсан “Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ” сургалтыг 2023.01.12-13-ны өдрүүдэд БЭХХТ-тэй хамтран зохион байгуулав. Уг 2 өдрийн сургалтад нийт 13 шинэ элсэлтийн бригадууд бүтэн ирцтэй оролцсон бөгөөд “Дулаалгын өртөг тооцоолол”, ногоон зээлийн танилцуулга болон “Дулаан шийдэл” веб системийн хэрэглээний зааварчилгаа, дадлага ажлуудыг хийж, байшингийн дулаан

алдагдлыг хэрхэн хэмжих, тооцоолох болон техникийн бичиг баримтууд болон үнэлгээний маягтыг веб системд хэрхэн бөглөх талаар суралцав. Цаашлаад төслийн “Технологийн болон Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээний” сургалтад бүрэн хамрагдсан 7-р ээлжийн бригадуудыг үе шаттайгаар дадлагажуулсан бөгөөд 2023.01.18-ны өдөр хүйтний улиралд хийгддэг газар дээрх “Камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт”-ыг хийлгүүлэв.

БЖДБЭ-Д ЗОРИУЛСАН БИЗНЕСИЙН МЭДЛЭГ ОЛГОХ БАГЦ СУРГАЛТЫН ХҮРЭЭНД ЗАХ ЗЭЭЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНТЭЙ УУЛЗАЛТ ХИЙВ

2023.01.13-нд “Зах зээл судлалын хүрээлэнгийн” Дэд захирал М.Сэлэнгэ-тэй “Дулаан шийдэл-2” төслийн шинэ элсэлтийн БЖДБЭ буюу 7-р ээлжийн шинэ бригадуудад зориулсан “Бизнесийн мэдлэг олгох багц сургалтын” хөтөлбөрийг шинэчлэх ажлын хүрээнд уулзалт хийв. Тус сургалтын зарим сэдвийг МБҮА ТББ-ын Төслийн баг нь 2022 оны Бригадуудын сэтгэл ханамжийн судалгааны сургалтын хэрэгцээ, шаардлага дээр үндэслэн хасаж, өөр бусад хэрэгцээтэй сэдвүүдийг шинээр нэмж тохируулах талаар хэлэлцэж нэгдсэн шийдвэрт хүрлээ.



“БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ БУЮУ КАМЕРТАЙ ХЭМЖИЛТИЙН НЭГДСЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ”





“Дулаан шийдэл-2” төслийн шинэ элсэлтийн БЖДБЭ буюу 7-р ээлжийн бригадуудад зориулсан “Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээний аргачлал буюу камертай хэмжилтийн дадлага” газар дээрх сургалтыг 2023.01.18-ны өдөр БЭХХТ-тэй хамтран зохион байгуулав. Тус сургалтаар БЭХХТ-ийн Захирал Б.Мөнхбаяр нь камертай хэмжилтийг хийх, мөн холбогдох маягтыг хэрхэн бөглөх талаар оролцогчдод зааварчилгаа өгсөн бөгөөд төслийн үйл ажиллагаанд идэвх чармайлттай оролцож буй зарим бригад, хувь хүнд эхний ээлжийн техникийн үнэлгээний багцыг гардуулав. Төслийн сургалтуудад бүрэн хамрагдсан бригад, хувь хүмүүс нь техникийн үнэлгээний дадлагад гарч эхэлсэн бөгөөд системд тест хэрэглэгчийг хуваарилах, веб суурьтай үнэлгээний маягтыг бөглөх, үнэлгээний хуудсыг оруулах, дадлагажигчийн тэмдэглэлийг хөтлүүлэх зэрэг ажлыг хийж сурав.

МБҮА ТББ-ЫН ДЭРГЭДЭХ БЖДБЭ-ИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ





“Дулаан шийдэл-2” Төслийн багийн хийж гүйцэтгэсэн бригадын ахлагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт дээр үндэслэн 2023.01.31-ны өдөр МБҮА ТББ-ын дэргэдэх Салбарын гишүүнчлэл болон үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Уг арга хэмжээгээр МБҮА ТББ-ын Дэд гишүүнээр элсэх хүсэлтэй 11 бригадын ахлагчтай уулзалт хийж 2023 онд нийт гишүүдийн дунд зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө болон Гишүүнчлэлийн гэрээний онцлох заалтууд, зайлшгүй мэдэх зүйлсийн талаар танилцуулав. Улмаар “Дулаан шийдэл-2” төслийн 11 бригадын ахлагч нь МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийн гэрээг байгуулж Дэд гишүүнээр элслээ.

“ДУЛААН ШИЙДЭЛ-2” ТӨСЛИЙН 2023 ОНЫ НАРИЙВЧИЛСАН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРЛАА

МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл-2” төслийн баг нь 2023 оны төслийн нарийвчилсан дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөг улирал болон сараар гаргалаа. Мөн 1-р сард хяналт үнэлгээний дэлгэрэнгүй төлөвлөгөө дээр МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл-2” төслийн баг нь ажиллаж байна. Мөн бригадуудад зөвлөгөөг өгөх, мэдээллээр хангах, камерыг хуваарилах гэх мэт өдөр тутмын ажлуудыг хийж гүйцэтгэв.

ТӨСЛИЙН БАГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ, ХҮСНЭГТЭЭР

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Бригадын ахлагчдад зуучилсан техникийн үнэлгээний захиалга	Камертай **60** Энгийн 11
2.	Техникийн үнэлгээний захиалга хуваарилсан бригадын ахлагч	8
3.	Бригадын ахлагчдын хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээ	34
4.	Бригадын ахлагчдад зуучилсан дулаалгын ажил	5
5.	7-р ээлжийн дадлагажуулсан бригадууд	13
6.	Бригадын ахлагчдад зориулж зохион байгуулсан сургалт, уулзалт, хурал, арга хэмжээ	3
7.	Дээрх сургалт, уулзалт, хурал, арга хэмжээнд оролцсон бригадын ахлагчид (давхардсан тоогоор)	36
8.	Арга зүйн зөвлөмж, туслалцаа үзүүлсэн бригадын ахлагч	8
9.	Техникийн үнэлгээ, дулаалга болон барилгын ажлын талаарх гарсан санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагч (давхардсан тоогоор)	20

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3: БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ


БҮАТЗХ-ийн “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл явц

2023.01-р сард “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 400 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр мэдээллээр ханган ажиллав.






БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрөл хүссэн 114 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, материалыг баталгаажуулж, Барилга, хот байгуулалтын яаманд 2023.01.05, 2023.01.12, 2023.01.19, 2023.01.26-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.



2023.01-р сарын байдлаар давхардсан тоогоор 426 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 4 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 114 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Үүнээс сунгалтаар 63, нэмэлтээр 27, шинээр 23, дахин олгохоор 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан.

Сунгалтаар 63 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас Барилга угсралтаар 58, Зураг төсөл боловсруулахаар 5, Нэмэлтээр 27 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас Барилга угсралтаар 16, Зураг төсөл боловсруулахаар 11, шинээр 23 ААНБ-ын хүсэлтийг хянаснаас Барилга угсралтаар 19, Зураг төсөл боловсруулахаар 4, дахин олгохоор 1 ААНБ-ын хүсэлт хянаснаас Барилга угсралтаар 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан байна. Эдгээр 4 удаагийн хурлаар давхардсан тоогоор 267 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүй учраас буцаав. 51 ААНБ-ын хүсэлт шалгагдахаар хүлээгдэж байна.



- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 114 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 935 инженер, техникийн ажилтны баталгаажуулалтыг хийв.
- 85 инженер, техникийн ажилтнуудын өргөдлийн дагуу хасалт, шилжилт хөдөлгөөнийг хийсэн байна.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж БХБЯ-д хүргүүлсэн.
- БҮАТЗ-тэй ААНБ-ын мэдээллийн санг үүсгэн www.mcis.gov.mn сайтаар нийтэд ил тод мэдээлж байна.
- БХБ-ын Сайдын тушаалыг үндэслэн 43 ААНБ-тай гэрээ байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 77,400,000₮-ийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- 2023.01-р сард үйлчилгээний хөлсөнд 114 ААНБ-аас 69,080,000₮-ийг Худалдаа хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- БҮАТЗ сунгуулах, нэмэлт ажилбар авахаар хүсэлт ирүүлсэн ААНБ-ын тайланг хянаж, БҮАТЗ-ийн хугацаанд гүйцэтгэсэн ажлуудын дагуу “Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэл”-ийн санд 20,244,201₮-ийг төвлөрүүлсэн байна.
- БХБ-ын Сайдын 2023.01.20-ны өдрийн №09 дүгээр тушаал, №10 дугаар тушаал, №11 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн үнэт цаасанд бичилт хийж баталгаажуулав.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.4: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

- МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2023.01.12-ны өдөр Монгол Улсын УИХ-ын дарга Г.Занданшатар тэргүүтэй УИХ-ын 76 гишүүдэд “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын саналын маягтыг бэлтгэн албан хүсэлтийн хамт албажуулан Төрийн ордонд хүргэв.
- 2023.01.25-ны өдөр Монгол Улсын Засгийн гарзын Хэрэг эрхлэх газраас Сангийн сайд Б.Жавхланд саналыг судалж, холбогдох арга хэмжээг авч ажиллах гэсэн хариу албан бичиг ирсний дагуу МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Л.Хулан, МЭХБЗХ-ны Тэргүүн Э.Мөндөр, МАЗХ-ны Ерөнхийлөгч Т.Бямбаа нарт мэдээллийг хүргэв.
- 2023.01.25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны Даатгагчийн баталгааг гаргах үйл ажиллагааны журмын төсөлд санал авах маягтыг бэлтгэж гишүүдэд түгээн санал авах ажлыг явуулж байна.
- МБҮА ТББ-ын Ажлын албаны 2023 оны Хөдөлмөрийн гэрээний болон Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний төслүүд, Ажлын гүйцэтгэл ур чадварын, үнэлгээний тушаал, журмын төслийг дахин боловсруулж Гүйцэтгэх захирлаар хянуулан албажуулав.
- МБҮА ТББ-ын 2022 оны тайлангийн хавсралтууд болох тогтоол, журам, тушаал, албан бичгийн цахим болон цаасаар бэлтгэн хавтаслав.
- МБҮА ТББ-ын info@mnca.mn цахим шууданг өдөр бүр шалгаж Гүйцэтгэх захирал болон холбогдох ажилтан руу шилжүүлэн ажиллаж байна.
- МБҮА ТББ-ын Ажлын албаны 01-р сарын уулзалт, цуглаан, арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг Ажлын алба, БҮАТЗХ, “Дулаан шийдэл-2” төслөөс нэгтгэн авч Outlook-н хуанлийнд өдөр тутам бүртгэж, холбогдох мэдээллийг хүргэн ажиллав.

ОФФИСЫН ТОХИЖИЛТ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, ХУДАЛДАН АВАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Ажлын алба (805, 806 тоотууд)-ны, БҮАТЗХ (811 тоот)-ийн өдөр тутмын компьютер, техник тоног төхөөрөмж, интернэт, утас, принтер, модем, сканер, гэрэл чийдэнгийн бүрэн бүтэн байдал, ажиллагаа, засвар үйлчилгээг IT-ийн Инженер О.Амартүвшинтэй хамтран шалгаж, холбогдох засвар үйлчилгээг тогтмол хийлгүүлэн ажилтнуудыг хүндрэлгүй, хурдан шуурхай ажиллах боломжоор хангахаас гадна “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д ажиллаж буй ажилтнуудыг ханиад томуу, халдвараас сэргийлэхэд зориулсан шилэн хаалтыг захиалан суурилуулах, холбогдох сар тутмын худалдан авалт болон шинэ сайдад зориулсан мөнгөн аяга, хадаг зэрэг худалдан авалтыг хийж ажиллав.





- IFAWPCA-ын Монгол Улсад зохио байгуулагдах Дунд хугацааны УЗХ-ын бэлтгэл ажлын хүрээнд оролцогчдод зориулсан тээвэр, автобус, тосох үйлчилгээ, аялал жуулчлалын үйлчилгээний үнийн саналын талаар судалгаа зэрэг мэдээ мэдээллийн судалгааг хийн цуглуулж, Хамтын ажиллагаа хариуцсан ажилтанд шилжүүлэв.
- БХБЯ санаачилж, Авто замчдын холбоо зохион байгуулж, АХБ санхүүжүүлсэн ФИДИК-ийн сургалт I ээлж 2023.01.5-07, II ээлж 2023.01.18-20, III ээлж 2023.01.25-27 тус тус зохион байгуулагдаж Ажлын албаны ажилтнууд оролцов. Тус сургалтаар дараах асуудлуудыг хөндсөн болно. Үүнд:
  - ФИДИК-ийн ерөнхий ойлголт,
  - ФИДИК-ийн гэрээний баримт бичгүүд,
  - ФИДИК-ийн Улаан ном (Ерөнхий зүйлүүд ба Захиалагч),
  - ФИДИК-ийн Улаан ном (Захиалагчийн санхүүжилт),
  - ФИДИК-ийн Улаан ном (Инженер),
  - ФИДИК-ийн Улаан ном (Инженер-Тохиролцох эсхүл Шийдвэрлэх),
  - ФИДИК-ийн Улаан ном (Гүйцэтгэгч),
  - ФИДИК-ийн Улаан ном (Туслан гүйцэтгэгч),
  - ФИДИК-ийн Улаан ном (Маргаан ба Арбитрын үйл ажиллагаа),
  - ФИДИК-ийн Цагаан ном (Зөвлөх үйлчилгээний гэрээ, түүний хэрэглээ) зэрэг байв.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.6: САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ:

МБҮА ТББ-ын 01-р сарын байгууллагын өдөр тутмын гүйлгээ, ашиглалт, түрээс, интернэт болон бусад холбогдох төлбөрийг цаг тухайд нь төллөө. “Дулаан шийдэл-2” төслийн сарын гүйлгээ болон өнгөрсөн 2022.11,12-р саруудын тайланг хийж гүйцэтгэв. Санхүүгийн программ дээр холбогдох журналын бичилт болон данс хоорондын төлбөр тооцоог тулгаж гүйлгээнүүдийг хийв. Төслийн сар бүрийн санхүүгийн товлогдсон хуралд сууж, зөвлөмж чиглэлийг мөрдөн ажиллалаа. БҮАТЗ-ийн хураамж төлөлтийн дагуу И-баримтыг холбогдох компани руу шивж ажиллав. Мөн Гишүүнчлэлийн татварын төлөлтийн 81%-г бүрдүүллээ. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн цогц тайлан, татварын тайлан, НӨАТ-ын тайлан болон Нийгмийн даатгалын тайлан гарган Хяналтын зөвлөл, БХБЯ-ны хуралд тайлагнав. Мөн 2022 оны бүх анхан шатны баримт болон тайлангаа архивлан дуусгасан.

МБҮА ТББ-ЫН 2022.01.31-НЫ ӨДРИЙН БАЙДЛЫН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ

Утга	Ажлын алба (₮)	БҮАТЗ (₮)
Харилцахын эхний үлдэгдэл	179,623,648.62	272,275,622.87
01-р сарын орлого	10,000,000	79,044,000
01-р сарын зардал	26,868,927.09	49,256,027.14
Харилцахын эцсийн үлдэгдэл	162,754,721.53	302,063,595.73

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.2: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

- МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Стратеги, бодлогын зөвлөх нэгж”-ийн Ажлын албатай 2023.01.09-ний өдөр хийсэн уулзалтаар “МБҮА ТББ-ын Стратеги төлөвлөгөө 2020-2024” тодотголын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 15 төслийг хэрхэн зохион байгуулалтайгаар хэрэгжүүлэх, цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн эрчимжүүлэх талаар ярилцлаа.
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн төслийн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тэнцвэртэй хангах заалтуудад бүтээн байгуулагчид болох Барилга, Эрчим хүч, Замын салбарын хувийн хэвшлийг төлөөлж Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ (МБҮА), Монголын эрчим хүчний барилга, засварчдын холбоо (МЭХБЗХ) болон Монголын авто замчдын холбоо (МАЗХ) зэрэг байгууллагууд хамтран боловсруулсан саналыг УИХ-ын дарга болон гишүүдэд 2023.01.12-ны өдрийн 23/03/АА тоот албан бичгээр хүргүүлэв.
- Барилгын мэдээлэлтэй загварчлал (BIM), барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем программ хангамжийг нэвтрүүлэх асуудлын хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж буй “BIM 2023” форумд Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ нь IFAWPCA-ийн гишүүн болох Сингапурын Барилгын ассоциацийн гишүүнийг Зочин илтгэгчээр цахимаар оролцуулах асуудлаар БХБЯ-тай хамтран ажиллахаар тодруулга авах 2023.01.13-ны өдрийн 23/04/АА тоот албан бичгийг хүргүүлж, тодорхой хариуг авав.
- БХБЯ, ГЗБГЗЗГ-аас хамтран зохион байгуулсан “Хот байгуулалтын тухай”, “Геодези, зураг зүйн тухай”, “Газрын ерөнхий хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай”, ”Кадастрын тухай”, ”Газрын төлбөрийн тухай”, “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай” хуулиудын төслийн хэлэлцүүлэг нь 2023.01.14-ний өдөр БХТ ТӨҮГ-ын Хурлын танхимд зааланд зохион байгуулагдаж, тус хэлэлцүүлэгт МБҮА ТББ-ыг төлөөлж Ажлын албаны Салбарын бодлого хариуцсан зөвлөх Г.Лосол оролцлоо.

2023 ОНД ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ХУУЛИУД НЬ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ХЭРХЭН ТУСАХ ВЭ

Бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулахад төрөөс гаргаж буй аливаа хууль тогтоомж, түүний өөрчлөлт нэн чухал байдаг бөгөөд Монголын бизнесийн зөвлөл (ВСМ) нь гишүүддээ зориулан 2023 оноос шинээр хэрэгжиж эхэлж буй болон нэмэлт өөрчлөлт орсон хуулиуд нь бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлөх талаарх сургалтыг Шангри-Ла зочид буудлын “Мэдлэг хуваалцах” танхимд 2023.01.25-ны өдөр зохион байгууллаа. Уг уулзалт арга хэмжээнд Монголын бизнес эрхлэгчдийн төлөөллүүд болон МБҮА ТББ-ыг төлөөлж Гүйцэтгэх захирал Л.Хулан оролцлоо. Шинээр хэрэгжиж эхэлж буй “Зөвшөөрлийн тухай”, нэмэлт өөрчлөлт орсон “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хувь хүний орлогын албан татварын тухай”, шинэчилсэн найруулгаар шинээр батлагдсан “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулиудын талаар “Өмгөөллийн легал мэйт” ХХК-ийн өмгөөлөгч Б.Батбаяр танилцуулга хийж, хаана, юун дээр анхаарах талаар зөвлөмж, зөвлөгөөг өглөө.

“ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ” ХУУЛЬ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА:

1. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.
2. Байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон зөвшөөрлийг хугацаатай олгоно.
3. Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.
4. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагааны хугацаа нь тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна. **ХЯНАЛТЫГ:**

Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана. Зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гүйцэтгэнэ. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ.

“АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ” ХУУЛЬ

Албан татвар төлөгчийн 2023.01.01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх дулаан, цахилгаан үйлдвэрлэх төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний:

- Эхний 3 жил нь 90 хувь хөнгөлөх,
- Дараагийн 3 жил нь 50 хувь хөнгөлөх,

Харин шулуун шугамын аргаар элэгдэл тооцох:

17.16 Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй албан татвар төлөгч нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нийслэл хотын Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон бусад аймаг, суманд шинээр бий болгосон энэ хуулийн

17.1 дэх хэсгийн 1-т заасан хөрөнгөд өөрийн сонголтоор 15 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдлийг тооцож болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгөд элэгдэл тооцож эхлэхээс өмнө харьяалах татварын албанд мэдэгдсэн байна.

15.5 Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгон нээлттэй арилжаалагдах үнэт цаас гаргасан тохиолдолд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах зардлыг 20 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

15.6 Авто тээврийн тухай хуулийн 3.1.11-т заасан нийтийн тээврээр нийслэл хот дотор зорчих тасалбар, эсхүл зорчих эрхийг бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ажилтандаа олгосон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн тухайн тасалбар, зорчих эрх худалдан авсантай холбогдох энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцно”.

22.5.4 “Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд Инновацын тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг” татварын хөнгөлөлтөд хамруулна. Хуучин 3 жил байсан бол 5 жил болгосон.

20.2.9 Программ хангамжийг боловсруулах, хөгжүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах

программ хангамжийн эрхийн шимтгэл, сервер түрээслэх төлбөртэй холбоотойгоор Монгол Улсад байрладаггүй этгээдэд шилжүүлсэн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна.
21.1.15 “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого”-ыг албан татвараас чөлөөлнө гэж хөнгөвчилж оруулж өгсөн байна.

“ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ” ХУУЛЬ

Тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг бусад байгууллагад шилжүүлсэн.

- Бүх яамнууд харьяалсан асуудлын хүрээнд хяналт шалгалт хэрэгжүүлэх ба дэргэдээ хяналт шалгалтын нэгжтэй байна.
- Яамнууд нь зарим хяналт шалгалтын чиг үүргээ холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно (татвар, нийгмийн даатгал, шударга өрсөлдөөний хэрэглэгчийн төлөө газар гэх мэт).

Харин шалгалтыг:

- Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор гүйцэтгэнэ.

Төрийн хяналт шалгалттай холбогдуулан анхаарвал зохих зүйлс

Удирдамжтай бол:

- Удирдамжийн бүрдэл хангагдсан байх
- Удирдамжгүй хийх шалгалт биш байх

Удирдамжгүй бол:

- Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд
- Шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол
- Хяналт шалгалтын байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр

“ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ” ХУУЛЬ

- Жилийн ₮0-₮120 сая хүртэлх албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10%
- Жилийн ₮120-₮180 сая хүртэлх албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд ₮12 сая дээр ₮120 саяас дээш давсан орлогод 15% нэмж тооцох
- Жилийн ₮180 саяас дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд ₮21 сая дээр ₮180 саяас дээш давсан орлогод 20% нэмж тооцохоор тусгажээ.

Ийнхүү тус хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт болон хяналт шалгалтын тухай мэдээллийг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд ямар зүйл заалтад хамааралтай эсэхийг нь тодотгож мэдээлэл өгөв.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.8: ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

МБҮА ТББ-ЫН ТӨСЛИЙН БАГУУД ТӨСЛҮҮДЭЭ ЭХЛҮҮЛЛЭЭ



МБҮА ТББ нь “Стратеги төлөвлөгөө 2020-2024” тодотголын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 15 төслийг хэрхэн зохион байгуулалтайгаар хэрэгжүүлэх, цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн эрчимжүүлэх талаар хэлэлцэж ярилцах зорилгоор 15 төслийн багийн ахлагчидтай 2023.01.17-ны өдөр МН Тауэрын 7-р давхрын Хурлын танхимд уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтад МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Дэд ерөнхийлөгч Б.Чимэгцэцэг, Гүйцэтгэх захирал Л.Хулан, Стратеги, бодлогын зөвлөлийн нэгжийн Дарга Ц.Өнөржаргал, Төслийн багийн ахлагчид, Ажлын албаны ажилтнууд оролцож, Төслийн багийн ахлагч нарын хариуцсан төслүүдийг хэрхэн, ямар үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар зөвлөлдөж, санал бодлоо хуваалцав.

МБҮА ТББ-ын УЗГ, “Макс өргөө” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, “Терминал” төслийн Багийн ахлагч Т.Түмэн-өлзий: ТӨСӨЛ НЬ АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖИХГҮЙ БАЙСАН Ч ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР НАДАД ТУРШЛАГА СУУХ НЬ ЧУХАЛ

Өөрийн хариуцан ажиллаж байгаа төслийг хэрэгжүүлэхийн төлөө би цаг заваа зарцуулан ажиллана аа. Энэ төсөл нь амьдрал дээр хэрэгжихгүй байсан ч ажлын гүйцэтгэлийн явцад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төслийн удирдлагын менежмент, арга зүйд суралцах, стандартыг хэрэгжүүлэхэд өөрийн биеэр оролцон суралцаж, цаашид эрхэлж байгаа бизнестээ туршлагаа нэвтрүүлэх нь онцлогтойг дурдав.

МБҮА ТББ-ын Стратеги, бодлогын зөвлөлийн нэгжийн Дарга Ц.Өнөржаргал: ЭНЭ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АРГА ЗҮЙГ НЬ ЗААЖ ӨГӨӨД ЯВЖ БОЛНО

Та бүхнийг өнөөдөр хүрэлцэн ирсэнд баярлалаа. Бид энэ талаар олон удаа уулзалдлаа. Ямар ч байсан Бүтээн байгуулалтын салбарын төслийн удирдлагын форумаа зохион байгуулаад төслүүдээ хуваарилж авсан алхмыг хийсэн байгаа. Тиймээс ямар төслийг, ямар цаг хугацаанд хийхээ товлоод хийх нь зүйтэй байх. Энэ төслийг хийхэд манай Зөвлөх баг та бүхний дэргэд байж, бүрэн зөвлөж туслан ажиллах болно. Тиймээс төсөлд үнэхээр орж ажиллах сонирхолтой хүмүүсийг оруулаад ажлаа эхлүүлээд явах нь зүйтэй байх. Өөрөөр хэлбэл, манай багт бүх төрлийн төслийг хийж явсан туршлагатай хүмүүс байгаа учир бүх түвшинд туслаад, хэрэгжүүлэхэд арга зүйг нь зааж өгөөд явж болно. Энэ нь урт хугацаандаа барилгын салбарт тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэхэд энэ төслүүд маань хэрэг болох юм.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: АЖЛАА ЯВУУЛАХ ОНОЛ АРГА ЗҮЙГЭЭР ТӨСЛӨӨ ХЭРЭГЖҮҮЛМЭЭР БАЙНА

Одоо бид энэ төслөө хэрэгжүүлэхийн тулд сэтгэлгээгээ өөрчилж, онол арга зүйгээр ажилламаар байна. Бүх гишүүдээрээ ярилцаж байгаад Стратеги төлөвлөгөөндөө тодотгол хийгээд Ажлын алба 6, Гишүүд 4, Ерөнхийлөгчид 8 гэсэн ажлуудыг хуваарилаад авсан байгаа. Тиймээс энэ ажлуудыг Ерөнхийлөгч нар ч тэр, Гишүүд ч тэр манлайлаад явахгүй бол урагшаа явахгүй ээ. Тиймээс энэ ажлаа хийе гэж бодож байгаа бол манлайлаад оролцоод, хэрэв оролцохгүй, идэвхгүй байх юм бол дахиад энэ талаар гомдоллоод, шүүмжлээд байх шаардлага байна уу.

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр: НЭГДСЭН САНАА БОДОЛТОЙГООР АЖИЛЛАХ НЬ ЗҮЙТЭЙ

Томоохон ажлын эхлэлийг тавьж байгаа хэн бүхэнд хэцүү байдаг. Ер нь томоохон төсөл хөтөлбөрийг орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, онол арга зүйтэй хийх нь үр дүн сайн байдаг. Энэ төслүүдийг хөдөлгөхийн тулд нэгдсэн санаатай, үзэл баримтлалтай, хариуцлагатай, шат шатны хурлаа цаг хугацаанд нь хийгээд явбал бид нар үр дүнд хүрнэ ээ.

МБҮА ТББ-ын УЗГ, “Тэсо пропертис” ХХК-ийн Бизнесийн хөгжлийн газрын Захирал, “Хөшгийн хөндийн төлөвлөлт” төслийн Багийн ахлагч П.Лхагвадорж: БОГИНО БОЛОН ДУНД ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДЭЭ ЭРЭМБЭЛЭЭД ЭХЛҮҮЛЬЕ

Манайхан төслөө хэт томоор хараад байх шиг байна. Тиймээс тухайн төсөл бүр дээр баг, зорилго, чиглүүлэгчээ тодорхой болгоод эхлүүлбэл зүйтэй байх. Энэ төслүүдээсээ ялгаж аваад богино, дунд хугацаанд гээд эрэмбэлээд хүчээ тарамдуулахгүйгээр ажиллавал хэрэгжиж болох юм шиг санагдаад байна. Шүүмжилж бол хэн ч чадна, тиймээс хүн болгон шийдлүүдээ хэлээд явбал болох байх.

МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан: АЖЛЫН АЛБА НЬ ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭХИЙН ТУЛД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ АЖИЛЛАНА

МБҮА ТББ-ын УЗГ нь 4 буюу 15 Төслүүдээ хэрэгжүүлэх, Ажлын алба нь 6 буюу Гишүүддээ чиглэсэн ажлаа, Ерөнхийлөгчид нь 8 буюу Нөлөөллийн ажлаа хийхээр ярилцаж баталсан байгаа. Тиймээс 15 төслүүдээ хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүнд аль төсөл нь эрэлт хэрэгцээтэй байгаагаар нь эрэмбэлээд Ажлын алба нь зохион байгуулалтын ажилд нь дэмжлэг үзүүлж ажиллана. Тиймээс энэ төслүүд дээрээ гишүүдээсээ дахин санал авч эхлүүлэх нь илүү дээр болов уу гэж бодож байна. Ажлын алба нь ажлаа эхлүүлээд ажиллаж байгаа. Эхнийх нь бол Тусгай зөвшөөрөл, дараагийнх нь “Дулаан шийдэл төсөл” буюу УБ хотын агаарын бохирдол, хүлэмжийн хийг бууруулах хүрээнд бригадуудыг чадавхжуулах ажлыг хийж байна. Удахгүй тэгээд Германаас “Сэргээгдэх эрчим хүч”-ний төсөл орж ирэх гэж байна.

МБҮА ТББ-ын УЗГ, “Би Ди Эм Ти” ХХК-ийн Захирал, “Гэр хорооллын дахин төлөвлөлт” төслийн Багийн ахлагч Ш.Мөнхсайхан: БҮТЦЭЭ ТОДОРХОЙ БОЛГООД, ХИЙЖ БҮЙ АЖИЛД НЬ ДӨХҮҮ ТӨСӨЛ РҮҮ ГИШҮҮДИЙГ ЧИГЛҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

Нэг үеэ бодвол манай МБҮА ТББ маань нэлээн томорч аливаа асуудлуудыг хэлэлцэж ярилцаж байгаад шийдвэрлэх боломжтой болсон байна гэж харж байгаа. Тиймээс улсын хэмжээнд гаргаад тавьсан зүйлийг эхлүүлэх нь зүйтэй байх. Зохион байгуулалтыг зөв хийгээд энэ төслүүдээ эхлүүлээд явах нь зүйтэй байх. Төслийн нэгжийн бүтэц дээр Удирдах зөвлөлийн гишүүд маань ямар чиглэлд бизнес хийж байгаа, тэрүүнд нь дөхүүлээд энэ төсөл нь тэдгээрийн хийж байгаа бизнест нь тус дөхөм болохоор оруулбал зүгээр байж болох юм. Миний хувьд, миний бизнес бол Гэр хорооллын дахин төлөвлөлт дээр ажиллаж байгаа. Тиймээс энэ төсөл дээр ажиллах хүсэлтэй байгаа.

МБҮА ТББ-ын УЗГ, “Оффис партнер” ХХК-ийн Захирал, “One world city” төслийн Багийн ахлагч А.Бүдээханд: ДОЛОО ХОНОГ БҮР ӨГЛӨӨНИЙ ЦАЙТАЙ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАНГАА АЖЛАА ЯРИЛЦАЖ БАЙЯ

Өнөөдөр энд бүгд цаг заваа зарцуулаад төслөө хэрэгжүүлэх гэж цугларч, багаа ахлаад явж байгаа. Тиймээс төслүүдээ хэрэгжүүлэх үүднээс түргэвчлэх, үр дүн гаргах тал дээр нь түлхүү ажиллаад долоо хоног бүрийн аль нэг өдөр нь өглөөний цайтай арга хэмжээг зохион байгуулангаа ажлын явцаа хэлэлцэж, төслүүдээ хэрэгжүүлээд явах нь хамгийн зүйтэй байх.

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Д.Өнөрболорын бие төлөөлөгч, “Гангийн үйлдвэр” төслийн Багийн ахлагч Г.Идэрхүү: УДИРДСАН ТӨСЛҮҮДЭЭ МАНЛАЙЛААД ОРОЛЦООД ЯВАХ НЬ ЧУХАЛ

Та бүхний саналтай 100 хувь санал нэгдэж байна. Манай багийн хувьд Гангийн үйлдвэрийн төсөл дээр ажиллаж байгаа. Харин энэ төсөл маань бэлэн байгаа учир багийнхаа хамт ороод гишүүдийн оролцоогоо хангаад ажиллахад бэлэн байна. Тиймээс бүгдээрээ удирдсан төслүүдээ манлайлаад оролцоод явах нь чухал шүү.

Ийнхүү уг уулзалтын үр дүнд Стратеги, бодлогын зөвлөлийн нэгж нь энэ 5 дахь өдөр төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа зарим мэдээллийг бэлтгэн явуулах, Ажлын алба нь гишүүдийн үйл ажиллагааны чиглэл болон боловсон хүчний нөөц бололцооны мэдээллийг 15 төслийг эрэмбэлэх санал хураалтыг цахимаар явуулах, үүний дагуу Төслийн багийн ахлагч нар нь шат шатныхаа хурлыг товлоод Стратеги, бодлогын зөвлөлийн нэгжтэйгээ хамтран төслүүдээ эхлүүлэх шийдвэрийг гаргаснаар уулзалт өндөрлөлөө.

БАРИЛГЫН САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН АСУУДАЛД ОНЦГОЙ АНХААРНА



Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд БХБЯ нь 3 зорилтын хүрээнд 20 ажлыг 2023 онд төлөвлөсөн бөгөөд түүний дотроос Удирдах түвшний бүрэлдэхүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй ижил түвшинд аваачиж ажиллахаа онцоллоо. 2022 онд БХБЯ нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн хүрээнд салбар байгууллагуудын хүрээнд олон ажлыг төлөвлөж хийсэн бөгөөд үүний үр дүнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Дэд зөвлөл нь шилдэг зөвлөлөөр тодорсон байна.

Иймд өнгөрсөн онд хийж хэрэгжүүлсэн ажлуудаа үргэлжлүүлэх, Барилга, хот байгуулалтын хүний нөөц, бүтээгдэхүүн, үйлчилгээг жендерийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжих, салбарт ажиллагсдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Түншлэгчид, хувийн хэвшлийн оролцоог дээшлүүлэх хүрээнд ажиллахаа БХБЯ-ны ТЗУГ-ын дарга, Жендэрийн Үндэсний хорооны салбар зөвлөлийн дэд дарга Д.Баярсайхан мэдэгдлээ. Уг ажлын хүрээнд МБҮА ТББ нь Гишүүн байгууллагуудын хүрээнд ногоон барилгын шийдлүүдэд чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах уриалга гаргах, цалин хөлс, ажлын байрны орчинтой холбоотой асуудлыг хүлээн авч шийдвэрлэх, ажилчдыг эрүүл мэндийн багц үзлэгт хамруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөгөөнд тусган ажиллахаар шийдвэрлэв. Уг салбар зөвлөлийн хуралдаан нь БХБЯ-ны Хурлын танхимд болсон бөгөөд яамны Салбар зөвлөлийн дэд дарга, ТЗУГ-ын дарга Баярсайхан, Нарийн бичгийн дарга Н.Лхамсэржид, БХТ ТӨҮГ, салбар түншлэгч байгууллагын төлөөллүүд болон МБҮА ТББ-ыг төлөөлж Ажлын албаны ХМОНХ менежер Б.Төвшинболор нар оролцлоо. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд хот суурин, барилга байгууламжийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, бүтээн байгуулах үндэсний чадавхыг

бэхжүүлэх, салбарын ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн мэдрэмжтэй бодлого үйл ажиллагаагаар дэмжих, салбарын хэрэглэгчид, түншлэгчдийн оролцоо нэмэгдэнэ хэмээн зорьж байгаа юм.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БҮХ ШАТАНД ОЛОН ТАЛТ ТҮНШЛЭЛИЙГ ОРОЛЦУУЛАХААР “АЖЛЫН ДЭД ХЭСЭГ”-ИЙГ БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 17 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлаас 2020.08.28-ны өдөр баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” УИХ-ын 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 5.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай УИХ-ын 24 дүгээр тогтоолын хавсралтын 4.2.10 дахь заалтуудын хүрээнд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг хянан шалгах, санал дүгнэлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг УИХ-ын гишүүн С.Ганбаатараар ахлуулан байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ц.Туваан, С.Чинзориг, Ч.Ундрам нар ажиллаж байна. УИХ-ын гишүүн, “Ажлын хэсэг”-ийн ахлагч С.Ганбаатар 2023.01.24-ний өдөр Төрийн ордны “Их засаг” танхимд МБҮА ТББ, Ажил олгогч эздийн холбоо, Хувийн эмнэлгүүдийн холбоо, Авто замчдын холбоо, Ноос ноолуурын холбоо, Мах үйлдвэрлэгчдийн холбоо, Арьс ширний холбоо, Хоршоологчдын нэгдсэн холбоо зэрэг мэргэжлийн холбоодын төлөөллүүдийг хүлээн авч уулзсан бөгөөд МБҮА ТББ-ыг төлөөлж Гүйцэтгэх захирал Л.Хулан оролцлоо. Уулзалтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг холбогдох төрийн байгууллага болон МБҮА ТББ, Ажил олгогч эздийн холбоо, Хувийн эмнэлгүүдийн холбоо, Авто замчдын холбоо, Ноос ноолуурын холбоо, Мах үйлдвэрлэгчдийн холбоо, Арьс ширний холбоо, Хоршоологчдын нэгдсэн холбоо зэрэг мэргэжлийн холбоодын төлөөллүүдийг оролцуулж байгуулахаар тогтож, төр засгаас гарч байгаа хууль, шийдвэр тогтоолуудын уялдаа холбоо, гаргаж байгаа шийдвэрүүд нь хувийн хэвшлүүдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа болон цаашид хууль эрх зүйн хүрээнд оруулах саналуудаа нэгтгэлээ. Үүнд:

✅ Засгийн газрын танхим нь аливаа гаргаж буй шийдвэрийн хувьд уялдаа холбоотой байх

✅ Төр засгийн шийдвэр, гаргаж буй хууль эрх зүйн асуудлын төсөлд хувийн хэвшлийн дуу хоолой, саналыг заавал тусгаж байх

✅ Харьяа яамнуудад хувийн хэвшлийн төлөөллийг орон тооны болон орон тооны бусаар байлгах

✅ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийцүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хэрэгжүүлэх

✅ Мэргэжлийн холбоодын тухай хууль болон Танхимын тухай хуулийн ялгаа, заагийг тодорхой болгох

✅ Төрийн бус байгууллагуудад гомдол шийдвэрлэх эрхийг өгөх зэрэг байв.

Түс “Ажлын хэсэг” нь байгуулагдсанаар эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны бүх шатанд гаргасан шийдвэрүүд, түүний биелэлт нь нийгэмд ил тод болохоос гадна, шат шатанд үүсэж буй хүнд суртал, хүмүүсийг чирэгдүүлж буй асуудлууд арилна гэж үзэж байгаа болно.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.6: ОЛОН УЛСЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

❖ Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн 2023 оны ДУНД ХУГАЦААНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫГ Монгол Улсад зохион байгуулах эрхийг авсны дагуу тус хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хурал зохион байгуулах газар, зочид буух зочид буудал, зочдын аялах аяллын чиглэл, тээвэр зэргийн үнийн судалгааг хийж, эдгээр мэдээллийг хөтөлбөртэй уялдуулан боловсруулав.

❖ Барилга, бүтээн байгуулалт, дотоод засал чимэглэлийн Азийн топ экспо “KOREA BUILD WEEK-2023” нь 2023.02.16-19-ний өдрүүдэд БНСУ-ын Илсан хотын “KINTEX” үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдах гэж байгаа бөгөөд үзэсгэлэнд МБҮА ТББ-ын 6 гишүүн байгууллагын 10 төлөөлөгчийг хамруулан оролцуулахаар болж, холбогдох логистикийн ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Тус үзэсгэлэнд дээрх байгууллагуудын төлөөллийг оролцуулахад БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагтай (KOTRA) хамтран ажиллав. “KOREA BUILD WEEK-2023” үзэсгэлэн нь дараах 7 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд:



- Барилгын материалын нэгдсэн үзэсгэлэн болох “Korea Build”,
- Угсармал бетон болон дижитал барилгын технологи “Modular & Pre-Con Korea”,
- Агаарын тоосонцрыг бууруулах шинэ технологи “Clean Air Expo”,
- Барилгын аюулгүй ажиллагааны технологи “Smart-Con Safety Korea”,
- Гал түймрээс урьдчилан сэргийлэх технологи “Building Fire Safety Korea”,
- Архитектурын засвар үйлчилгээний салбар “Facilities Management Expo”,
- EV цэнэглэгчийн дэд бүтцээр мэргэшсэн “EV Charger Korea”

Дараах давуу талуудтай:
JHBS буюу Японы хамгийн том орон сууц, барилгын үзэсгэлэн, Fenestration Bau China буюу БНХАУ-ын цонх хаалганы үзэсгэлэн, IBS буюу АНУ-ын №1 Олон улсын архитектурын үзэсгэлэн, WOC буюу №1 Бетон ба барилгын үзэсгэлэн, MosBuild буюу ОХУ-ын №1 Олон улсын архитектурын үзэсгэлэн, CIS болно Batimat буюу ЕХ-ны шилдэг үзэсгэлэн зэрэг 25 улс орнуудын дэлхийн шилдэг үзэсгэлэнгүүдийг хамруулан хамтран ажиллаж байгаа болно.

ТАЙЛАНД УЛС БАРИЛГЫН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ТӨЛБӨРИЙН МАРГААНТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙГ САНААЧИЛЛАА



2023 оны байдлаар Тайланд Улсад барилгын гэрээг зохицуулах тусгай хууль байдаггүй байна. Барилгын үйлчилгээ нь Тайландын Иргэний болон Худалдааны хуулийн (ССС) 587-р хэсэгт заасан ажил эрхлэлтийн ерөнхий ангилалд багтдаг бөгөөд ССС-ийн 587-607-д заасан заалтуудыг дагаж мөрдөн хэрэгжиж ирсэн байна. Харин энэ салбарт байнга гардаг практик маргааныг шийдвэрлэхэд ССС-ны дээрх 21 ерөнхий заалт нь хангалтгүй байдаг байна. Тайландын хууль тогтоомж нь талуудад гэрээний нөхцөлийн талаар амаар болон бичгээр тохиролцохыг зөвшөөрдөг бөгөөд эдгээр нөхцөл нь заавал дагаж мөрдөх хууль тогтоомж, нийтийн хэв журам, ёс суртахуунтай харшилдаггүй учир гэрээ эсвэл түүний аль нэгийг нь биелүүлдэг байна. Мөн тус улсад *барилгын гэрээний дагуу ажил гүйцэтгэх хугацаа нь хоцорсон тохиолдолд төслийн эзэнд гэрээний үнийг төлөхөөс татгалзах, эсвэл гүйцэтгэгчид нь торгууль ногдуулах эсвэл хойшлуулсан хохирлыг барагдуулахыг зөвшөөрдөг* аж.

Нэмж дурдахад, туслан гүйцэтгэгч нь төслийн өмчлөгчөөс төлбөр хүлээн авах хүртэл (заримдаа “төлсөн үед төлөх” зарчим гэж нэрлэдэг) туслан гүйцэтгэгчид гэрээний үнийг төлөх шаардлагагүй гэсэн “нөхцөлтэй төлбөрийн” заалтуудыг гэрээнд ихэвчлэн оруулдаг. Эдгээр болзошгүй төлбөрийн заалтууд нь Тайландын хуулийн дагуу ерөнхийдөө хэрэгждэг.

Барилгын салбарын *маргааны гол шалтгаануудын нэг бол төлбөрийн асуудал* байдаг. Ийм маргааны шүүх буюу Арбитрын ажиллагаа нь нэлээд урт хугацаанд үргэлжилдэг бөгөөд зардал ихтэй учир ихэнхдээ гэрээлэгч эсвэл туслан гүйцэтгэгчид нь төлөх ёстой төлбөрөө бүрэн буцаан олгохоос татгалздаг.

Хууль тогтоомжийн өнөөгийн байдал нь Тайландын барилгын салбарт сөргөөр нөлөөлж, барилгын ажлыг түр зогсоох эсвэл бүр зогсооход хүргэж болзошгүй эрсдэлүүдийг гаргаад байгаа. Барилгын төсөлд үндсэн гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, төслийн инженер зэрэг янз бүрийн түвшний олон талууд оролцдог тул төлбөрийн маргаанаас үүдсэн аливаа саатал нь асар их алдагдалд хүргэж, доод түвшний талуудад домино эффектийг үүсгэдэг байна. Практикт (ФИДИК)-ийн гэрээнд заасан Маргаан шийдвэрлэх зөвлөл (DAB) гэдэг ойлголт нь Тайландад хэрэглэгдэж буй маргааныг шийдвэрлэх зуучлагчийн ердийн механизм биш юм. Өөрөөр хэлбэл, маргааныг талуудын хоорондоо найрсаг хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх боломжгүй бол шүүх, арбитрын ажиллагааг эхлүүлэх ёстой гэсэн байдаг. Иймд Тайланд Улсад хугацаа хоцорсон төлбөртэй холбоотой бэрхшээлийг арилгахын тулд хууль тогтоогчид нь барилгын гэрээг зохицуулах хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд үүний дагуу шүүх үйл ажиллагаа болох юм.

Хуулийн төслийн танилцуулга

“Барилга угсралтын гэрээний төлбөртэй холбоотой маргаан шийдвэрлэх тухай” хуулийн (“Төлбөр”)-ийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд одоогоор нийтийн хэлэлцүүлгийг хийж

байна. Хуулийн төслийн дагуу төлбөрийн маргааныг гүйлгээний зардал багатайгаар шуурхай шийдвэрлэх, ингэснээр талуудын бодит шаардлагад хариу өгөх боломжтой болох юм.

Хэрэглээний хамрах хүрээ:

Уг хуулийн төсөл нь Тайландын хууль тогтоомжоор зохицуулагдсан эсэхээс үл хамааран бичгээр хийгдсэн, барилгын ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хийж байгаа аливаа барилгын гэрээнд хамаарна. Харин уг төсөл нь зөвхөн ҮХЦ-ээр зохицуулагддаг аман барилгын гэрээнд хамаарахгүй. Мөн хуулийн төсөлд харш, эсхүл үл нийцэх аливаа гэрээний заалт эсвэл барилгын гэрээг хуулийн төслийн заалтад хамаарахаас чөлөөлөхийг хүссэн аливаа хэлэлцээр нь хүчингүй болно гэж тодорхой заасан байна. Иймээс Тайландад гүйцэтгэх барилгын ажлын гэрээ нь гадаад улсын хуулиар зохицуулагдсан хэвээр байж болох ч уг хуулийн төслийг нийтийн хэв журамтай холбоотой хууль гэж үзэх тул хуулийн төслийн заалтад нийцсэн байх шаардлагатай.

Төлбөрийн маргааны зохицуулалт:

Барилгын гэрээнд “Төлбөр төлсөн үед нь төлөх” заалтыг хориглож өгсөн. Энэхүү хязгаарлалтын зорилго нь гэрээний дагуу үнийг гүйцэтгэгчид нь зохих ёсоор төлнө. Өөрөөр хэлбэл, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид нь Төслийн эзэмшигчээс үндсэн гүйцэтгэгч төлбөрөө авсан эсэхээс үл хамааран талуудын тохиролцсон нөхцөлийн дагуу үндсэн гүйцэтгэгчээс төлбөр авах боломжийг олгож байгаа юм.

Шүүх хурал:

Шинэчлэн санаачилж байгаа хуулийн төсөлд Барилгын гэрээний оролцогч төлбөрийн маргааныг өөр маргаан болгон Арбитрын шүүхэд гаргах эрхийг хуулиар олгосон. Шүүгчийн шийдвэр нь талуудын маргааныг дараагийн Арбитрын болон шүүх хуралдааныг хүлээлгүйгээр эцсийн шийдвэр биш байсан ч нэн даруй төлөх үүрэгтэй. Энэхүү механизм нь ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нарт ажлаа түр зогсоох, зогсоохгүйгээр тус тусын гэрээний дагуу ажлаа үргэлжлүүлэх боломжийг олгож байгаа юм.



МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ

Монгол Улс, Улаанбаатар 15141
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

+ (976) 7011 1515, 9444 4173

info@mnca.mn

www.mnca.mn